

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэгч: Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн
Газарзүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор, Газар зохион
байгуулалтын мэргэшсэн инженер  Г.ГАНТУЛГА

АГУУЛГА

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	1
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ	1
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ.....	2
3.1. Зорилгод хүрэх байдал.....	2
3.2. Ойлгомжтой байдал.....	8
3.3.Зардал.....	11
3.4. Харилцан уялдаа.....	11
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ	12

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-д Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан үр нөлөөний үнэлгээ хийж, зөвлөмж гаргах зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д зааснаар уг тайланг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн үр нөлөөг аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа.

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь зорилго, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц байна уу гэдгийг тогтоох зорилгоор сонгосон болно.

Ойлгомжтой байдал: Энэхүү шалгуур үзүүлэлтийн тухайд дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлов:

1. Хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын хувьд ойлгомжтой эсэх;
2. Хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх;
3. Агуулга, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, тодорхой эсэх.

Зардал: Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэлт зардал үүсэхгүй гэж үзэв.

Харилцан уялдаа: Хуулийн төслийн зүйл, заалт нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгосон.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл

			боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар ойлгомжтой байдлыг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр улс болон орон нутгийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардах эсэх, нэмэлт зардал гарах эсэхийг шалгах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Энэ тайлангийн 2 дугаар зүйлд урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлт, тэдгээрт хамаарах шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийлээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

№	Үзэл баримтлалд тусгагдсан зохицуулах харилцаа	Хуулийн төсөлд тусгагдсан зүйл заалт	Үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэх
1	Улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор газрыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлж, ашиглуулах бөгөөд газрын зориулалтыг бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн онцлогт нийцүүлэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох;	“20.1.8.Энэ хуулийн 33.5-д заасан улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн хэмжээнд төсөл шалгаруулах зарчмаар эзэмшүүлэх газрын зориулалтыг тогтоох.” (шинээр нэмсэн) “33.5.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл мал аж ахуйн үйлдвэрлэл	Орон нутагт аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, ажлын байрыг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломжийг нэмэгдүүлж, газрыг илүү үр дүнтэй ашиглаж, газраас хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно. Ингэснээр богино хугацаанд газрын дуудлага худалдаанаас олж буй орлогын хэмжээ буурах магадлалтай хэдий ч урт, дунд хугацаандаа газрын төлбөр, газар дээр явуулж байгаа үйл ажиллагааны татварын орлого нэмэгдэж, татварын бааз тэлж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төсөл сонгон

		эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт, эсхүл улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор олгоно.” (өөрчлөн найруулсан)	шалгаруулалтын зарчмаар газрыг олгох, төсөл сонгон шалгаруулалтаар олгох газрын зориулалтыг нутгийн өөрөө удирдах байгууллага тогтоодог байх нөхцөл бүрдэнэ.
2	Засгийн газраас тухайн жилд улсын хэмжээнд хөдөө аж ахуй, хот суурин, зам, шугам сүлжээ, улсын тусгай хэрэгцээний газар зэрэг Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд орох томоохон өөрчлөлтийг төлөвлөх;	23 дугаар зүйлийн 23.2.3, 23.2.4 дэх заалт: “23.2.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих.” (Өөрчлөн найруулсан) “23.2.4.улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын шилжилт хөдөлгөөний жилийн төлөвлөгөөг боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.” (өөрчлөн найруулсан) “23.3.10.сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих.” (Аймаг, нийслэлийн газрын албаны эрх хэмжээнд нэмсэн)	“Засгийн газраас хот сууриныг тэлэх, тариалангийн газрыг шинээр бий болгох, зам, шугам сүлжээ байгуулах, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах зэрэг газрын нэгдмэл санд орох томоохон өөрчлөлтийг бодлогын түвшинд төлөвлөснөөр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээнд шаардагдах газартай давхардсан газар олгох, улмаар их хэмжээний нөхөн олговор олгох эрсдэлийг бууруулж, хот суурины газрын хяналтгүй тэлэлтийг хязгаарлах, газрын сангийн өөрчлөлтийг үр дүнтэй зохицуулах боломж бүрдэнэ. Дээрх төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулалтад хяналт тавих, газар олгох асуудлыг орон нутаг бие даан шийдвэрлэх боломж бүрдэж, шат дамжлага багасаж, иргэдэд шуурхай, хүндрэл, чирэгдэлгүйгээр газар олгох нөхцөл бүрдэнэ,” гэсэн үр нөлөөг нийгэм, эдийн засагт үзүүлнэ гэж заасан байна. Засгийн газраас эзэмших, ашиглах газрын хэмжээ байршил зориулалтыг тогтоодог байдлыг өөрчилж газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын шилжилт, хөдөлгөөнийг төлөвлөхөөр тусгасан нь орон нутагт шууд үр нөлөөгөө үзүүлж газар

			олгох үйл ажиллагааны хугацаа Засгийн газрын тогтоол хүлээх шаардлагагүй хурдан хугацаанд шийдвэрлэгдэх боломж бүрдэхээр байна. Мөн бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргахаар заасныг өөрчилж аймаг, нийслэлд Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт аймаг, нийслэлийн газрын алба дүгнэлт гаргаж хяналт тавихаар заасан нь эрх үүргийг шаталсан байдлаар хувиарлаж, газар олгох үйл ажиллагааны шат дарааллыг бууруулах нөлөө үзүүлэхүйц өөрчлөлт болсон байна. Иймээс хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд тусгагдсан хэрэгцээ шаардлагад заасан газрын асуудлыг орон нутагт бие даан шийдвэрлэх хэрэгцээ шаардлагыг эдгээр заалтууд нь хангаж байна.
3	Газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн аймаг, суманд газрын зориулалтыг өөрчлөх боломжийг бүрдүүлэх;	“21.3.3.аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох, дуусгавар болгох, газрын байршил болон хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг шийдвэрлэх. 21.4.8.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох, дуусгавар болгох, газрын байршил болон хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг шийдвэрлэх.”(шинээр нэмсэн)	“Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Газрын тухай хуулиар газрын байршил, зориулалтыг өөрчлөх асуудлыг зөвхөн нийслэлийн Засаг даргад олгосон байдаг бөгөөд орон нутагт зориулалт өөрчлөх хууль эрхзүйн зохицуулалтгүй байгаагаас хууль нийслэл, орон нутагт тэгш үйлчлэхгүй, орон нутгийн иргэдийн газрын байршил, зориулалтаа төлөвлөлтийн дагуу өөрчлөх асуудлыг шийдвэрлэх боломжгүй, зохицуулалтгүй байна. Иймд Газрын зориулалтыг өөрчлөх эрхийг зөвхөн нийслэлийн Засаг даргад олгосныг орон нутгийн хувьд ижил төстэй эрх зүйн зохицуулалт бий болгож, орон нутагт гэр хорооллыг орон сууцжуулах, газар ашиглалтыг төлөвлөлтийн дагуу оновчтой, үр ашигтай

		29.11.Энэ хуулийн 29.10-т заасан болон эзэмшил газрын зориулалт өөрчлөх шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэл, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.” (өөрчлөн найруулсан)	зохион байгуулах боломж бүрдэнэ.” Гэж үр нөлөөлөл бий болохоор үзэл баримтлалд заасан байна. Хуулийн төсөлд тусгагдсан зориулалт өөрчлөхтэй холбоотой зүйл заалтууд нь хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зохицуулах, харилцаа, хэрэгцээ шаардлага, зорилго зорилтод нийцэж байна.
4	Гэр бүлийн хэрэгцээнд газар эзэмшүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан, гамшгийн улмаас орон гэрээ алдсан иргэдэд эрэмбэ, дараалал харгалзахгүй газар олгох;	29 дүгээр зүйлийн 29.13, 29.14 дэх хэсэг: “29.13.Тухайн аймаг, сумын засаг захиргааны нэгжид харьяалалтай, өмнө нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй газар эзэмшиж, өмчилж байгаагүй иргэний хүсэлтийг энэ хуулийн 29.8.1-д заасан эрэмбийн эхэнд бүртгэнэ. 29.14.нийслэлээс хөдөө орон нутагт шилжин ирсэн, гамшиг ослын улмаас орон гэргүй болсон, эсхүл нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмших хүсэлтийг эрэмбэ, дараалал харгалзахгүй шийдвэрлэнэ.” 33 дугаар зүйлийн 33.9, 33.10 дахь хэсэг: “33.9.Энэ хуулийн 33.7, 37.2, 38.4-т заасан хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ хуульд зааснаас бусад нөхцөл, шаардлага тавихыг хориглох бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй бол тухайн	“Цахим хэрэглээнд бүрэн суралцаагүй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэд гэр бүлийн хэрэгцээний газрыг эрэмбэ, дараалал харгалзахгүй авах, мөн газраа авч чадаагүй иргэд нэн тэргүүнд харьяа орон нутагтаа газар эзэмших боломжтой болно. Ингэснээр орон нутагт иргэд газартай болох боломж нэмэгдэж, газар олголт хэрэгцээ шаардлагатай иргэддээ хүрч, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.” Гэж хуулийн төслийн үзэл баримтлалд үр нөлөөллийг тодорхойлсон байна. Хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим зүйл заалтууд нь тухайлбал өндөр настанд эрэмбэ дараагүй газар олгох асуудал нь Хуулийн төсөлд тусгагдаагүй, бусад асуудал нь үзэл баримтлалтай нийцэж байна.

		шатны Засаг дарга шалтгаан, үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэх үүрэгтэй. 33.10.Хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл энэ хуулийн 33.9-д заасныг зөрчсөн тухай гомдлыг нийслэл, дүүрэгт Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлд, аймаг, суманд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд тус тус гаргана.” 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг: 29.8.Иргэний үнэ төлбөргүйгээр газар эзэмшихээр гаргасан хүсэлтийг дараах дарааллын дагуу цахим системд бүртгэнэ:	
5	Газар ашиглалтын дэглэм, хориглолт, хамгаалалт, хязгаарлалт, ойн, усны сан, тусгай хамгаалалттай газар, газрын тос, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн орон зайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн нэгдсэн цахим системд холбогдох байгууллага нь бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд цаг тухайд нь бүртгээгүйгээс үүсэх үр дагаврыг тухайн байгууллага хариуцах;	“24.8.Хууль тогтоомжийн дагуу тогтоосон газар ашиглалтын дэглэм, горим бүхий хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газар болон зам, шугам сүлжээ, ойн сан, усны сан, тусгай хамгаалалттай газар, газрын тос, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлттэй талбайн орон зайн мэдээллийг тухайн мэдээллийн санг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага нэгдсэн цахим системд бүртгүүлэх үүрэгтэй.” (шинээр нэмсэн)	“Салбарын мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүрэн, цаг тухайд нь бүртгүүлэхийг үүрэгжүүлснээр газар ашиглалтад тавих хяналт сайжирч, салбар хоорондын уялдаа бүрэн хангагдан, нотолгоонд суурилсан орон зайн шийдвэр гаргах боломж бүрдэж, газрын маргаан, зөрчил буурах нөхцөл бүрдэнэ.” гэж хуулийн төслийн үзэл баримтлалд үр нөлөөллийг тодорхойлсон байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын зохицуулах харилцаанд тусгагдсан цаг тухайд нь бүртгээгүйгээс үүсэх үр дагаврыг тухайн байгууллага хариуцах тухай агуулга хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Уг асуудлыг хууль санаачлагчаас тодруулахад Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд тодорхой хариуцлагууд тусгагдсан тэдгээр

			зохицуулалтуудын дагуу хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэнэ гэх хариу өгсөн. Нэг талаар эдгээр нь үндэслэлтэй нийтлэг харилцаа хэдий ч хариуцлагын талаарх зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй байна.
6	Мал аж ахуй эрхлэх, тэжээлийн ургамал тариалахад зориулан малчдад тодорхой хэмжээний газрыг орон нутгаас эзэмшүүлэх.	29 дүгээр зүйлийн 29.3.1, 29.3.2 дахь заалт: “29.3.1.газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан тариалангийн газрыг үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл; 29.3.2.тариалангийн бүс нутгаас бусад газарт мал аж ахуйн салбарт 5-аас доошгүй жил тогтвортой ажилласан малчин иргэн малчин өрхийн хэрэгцээнд дундаа хамтран тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 5 га хүртэл.” “52.14.Энэ хуулийн 29.3, 52.7-д заасан газрын хэмжээнд нийцүүлэн эзэмшүүлэх газрын дээд хэмжээ, өвөлжөө хаваржааны газар болон инженерийн хийцтэй худаг, цооног байгуулах байршил хоорондын зайны доод хэмжээг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно. Эдгээр зай, хэмжээг зөрчиж газар эзэмшүүлэхийг хориглоно.”	“Малчид өөрсдийн хэрэгцээнд тэжээлийн ургамал тариалах боломжийг бүрдсэнээр мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг болно. Мөн 2024 онд батлагдсан Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд зааснаар “өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах” гэж заасан байдаг тул өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлэх газрын талбайн хэмжээ, маргаан үүсгэдэг өвөлжөө, хаваржааны хоорондох зай, уст цэг гэх мэт нийтээр ашигладаг байгууламжуудын зайг орон нутаг нь өөрөө тогтоож, маргаан үүсэх эрсдэлээс сэргийлэх, тэжээлийн ургамал тариалах боломжийг бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.” гэж хуулийн төслийн үзэл баримтлалд үр нөлөөллийг тодорхойлсон байна. Хуулийн төсөлд тусгагдсан зүйл заалтууд нь хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зохицуулах, харилцаа, хэрэгцээ шаардлага, зорилго зорилтод нийцэж байна. инженерийн хийцтэй худаг, цооног байгуулах газар хоорондын зай, өвөлжөө,

		хаваржааны газрын зориулалт өөрчлөхийг хориглох, газрын хэмжээний хязгаары тогтоож өгсөн нь үзэл баримтлалд тодорхой тусгагдаагүй ч үзэл баримтлалд заасан мал аж ахуй эрхлэхэд зориулан газар эзэмшүүлэх гэсэн хуулийн зохицуулах харилцаанд нийцэж байна.
--	--	---

Эдгээр асуудлыг зохицуулахаар тусгагдсанаар хуулийн төсөл нь хуулийн үзэл баримтлалд туссан зорилго, зорилт, хэрэгцээ гаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Харин үзэл баримтлалд тусгагдсан зохицуулах харилцаанд тусгагдсан зарим агуулгууд хуулийн төсөлд тусгагдаагүй байна.

3.2. Ойлгомжтой байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага”-д заасны дагуу дараах байдлаар үнэлэв.

Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага		
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Шаардлагыг хангасан.
2.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлагыг хангасан.
3.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлагыг хангасан.
4.	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Хуулийн төслийн 29.8, 29.13 дахь хэсгүүд хоорондоо зөрчилтэй. 33.9 дэх хэсэгт хүсэлт шийдвэрлэхтэй холбоотой хугацаа заасан боловч, уг хэсэгт 33.7 дахь хэсэг буюу хүсэлттэй холбоогүй заалтыг эшлэсэн байна.
5.	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Хуулийн зүйл, хэсэг заалт бүрийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон.
Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага		
6.	Хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийг хэл зүй, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл, бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар байх	Хуулийн төслийн 52.14-ын найруулгыг сайжруулах, 52.14-т заасан өвөлжөө, хаваржаа хоорондын зай, эсхүл өвөлжөө хаваржаа, худаг хоорондын зай

		аль нь болох нь тодорхойгүй байна. Мөн уг хэсэг нь хэт урт 2 өөр агуулгыг нэг хэсэгт багтаасан нь оновчгүй, ойлгоход төвөгтэй байна.
7.	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байх	Шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга, аргачлал		
8.	1.Нэр томьёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох	Хуулийн төсөлд шинэ нэр томьёо тусгагдаагүй. Шаардлага хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавигдах шаардлага		
9.	Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгийг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан байна. Гэсэн хэдий ч хуулийн төслийн зарим зүйлүүдийг аргачлалын дагуу сайжруулах шаардлагатай. Тухайлбал 29.3, 52.14, 29.8, 33.9 гэх мэт.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан болно. Үүнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулга	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал

болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төслийн 29.8, 33.9 дэх хэсгүүдэд хуулийн бусад заалттай нийцэхгүй байдал илэрсэн.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.3.Зардал

Зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу үзэхэд улсын болон орон нутгийн төсөв, мөн иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсэхгүй болно.

Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд заасан захиалагчид нэмэлт зардлын ачаалал үүсэхгүй.

3.4. Харилцан уялдаа

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан эсэхийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-д заасан 16 асуулт тус бүрд хариулах замаар шалган тогтоолоо.

№	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Бусад хуулийн заалттай нийцэж байна.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл, заалтууд хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай давхардсан байдлаар тусгагдаагүй байна.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд холбогдох этгээдүүдийн хэрэгжүүлэх чиг, үүргийг тодорхой тусгасан байна.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй байна.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм зохицуулалт тусгагдаагүй байна.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамжтай холбоотой зохицуулалт агуулагдаагүй байна.
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусаагүй байна.
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Монгол Улсын Үндсэн Хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан агуулга бүхий зохицуулалт уг хуулийн зүйл, заалтад тусгагдаагүй байна.
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг зөрчих ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй байна.
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгох, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй байна.
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт тусгагдаагүй байна.
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм зохицуулалт тусгагдаагүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хамаарах зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тухайлбал, Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгод тулгуурлан боловсруулсан хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд дүн шинжилгээ хийхэд тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгодоо хүрэх боломжтой байна.

Төслийн ойлгомжтой байдлыг хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг дүгнэхэд энэ төрлийн зөрчил тогтоогдоогүй болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хувьд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсхүл зөрчилдөж байгаа эсэхийг шалгаж дүгнэлээ.

Иймд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон дээрх 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зохицуулах харилцаа, хамрах хүрээг хангасан байна.

Энэхүү хууль нь хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томъёолол ойлгомжтой, хоёрдмол утга санаа агуулаагүй, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалт нь давхардаагүй, зөрчилдөөгүй, холбогдох субъектүүд хүлээн зөвшөөрөх боломжтой гэж дүгнэж байна.

Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримтлан хуулийн төслийг сайжруулах. Тухайлбал хуулийн төслийн 29.3, 29.12, 52.14 гэх мэт хэсгүүдийг өөрчлөх, нэмэлт оруулах, өөрчлөн найруулах зэрэг зүйлд хамруулах асуудлыг дахин нягталж, найруулгыг сайжруулан хуулийн төслийг засварлах шаардлагатай.

Мөн хуулийн төслийн 29.8, 33.9 зэрэг хуулийн бусад заалттай зөрчилтэй байж болзошгүй заалтуудыг нягталж, томъёолол, найруулгыг сайжруулахыг зөвлөмж болгож байна.

Түүнчлэн хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн бэлчээрийн газрын харилцаанд бий болох өөрчлөлтүүд болон цаашид бэлчээрийн газрын тогтвортой ашиглалтыг дэмжихэд чиглэсэн бэлчээр ашиглагчдад тавих хязгаарлалт, хариуцлагын шинжтэй зохицуулалтуудыг нэмж тусгахыг зөвлөмж болгож байна.

---o0o---